



ХУУЛЬ ЗҮЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Эрх чөлөөтэй  
байхын тулд хуульд  
захирагдах хэрэгтэй  
Ж.Амарсанаа

# Хууль зүйн мэдээ

www.nli.gov.mn

Хууль зүйн мэдээллийн сар тутмын цахим сонин

2023.03#31



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- ЭРҮҮГИЙН ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/
- ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ  
/Шинэчилсэн найруулга/
- БУСАД ХУУЛЬ
- УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ, ЗӨВЛӨМЖ

Үндэс-боолоор хот  
2023 он

ТА ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЭМХЭТГЭЛИЙГ  
ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН  
"ХУУЛЬЧДЫН НОМЫН ХУДАЛДАА"-НААС  
25.000₮ АВАХ БОЛОМЖТОЙ.



Хаяг: Хууль зүйн үндэсний  
хүрээлэн, Хууль зүйн үндэсний  
хүрээлэнгийн байр, Хуульчдын  
гудамж 1, Бага тойруу, 4 дүгээр  
хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот – 15160

## ЯПОН, МОНГОЛ, УЗБЕКИСТАН УЛСЫН ХАМТАРСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЕМИНАР АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн Япон Улсын Хууль зүйн яамны харьяа Сургалт, судалгааны хүрээлэн (RTI)-тэй 2021 онд байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд “Гэмт хэргийн статистикийг боловсруулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ашиглах нь” сэдэвт Япон, Монгол, Узбекистан Улсын хамтарсан эрдэм шинжилгээний семинар Япон Улсын Хууль зүйн яамны санхүүжилтээр 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 03 дугаар сарын 08-ны өдрүүдэд

Япон Улсын нийслэл Токио хотноо Сургалт, судалгааны хүрээлэнд амжилттай зохион байгуулагдлаа. Тус семинарт Монгол Улсын талаас ХЗҮХ-ийн Захирал Х.Эрдэм-Ундрах, Эрдэм шинжилгээний ажилтан Х.Буянбат, Д.Дэмидханд, С.Мягмарсүрэн, О.Энххүслэн нар, Япон Улсын талаас Сургалт, судалгааны хүрээлэнгийн захирал Тошинобү Уэтоми, тус хүрээлэнгийн Олон улсын хамтын ажиллагааны газрын (ICD) дарга Шинтаро Найто, орлогч дарга Хироши

Сүда, тус хүрээлэнгийн Судалгааны газрын орлогч дарга Кожи Ёшимүра, Олон улсын хамтын ажиллагааны газрын профессор Минако Шожи, Хироки Күнии нар, Узбекистан Улсын талаас Бүгд Найрамдах Узбекистан Улсын Хууль сахиулах академийн захирлын үүрэг гүйцэтгэгч Евгений Коленко, тус академийн Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах, дүн шинжилгээний төвийн тэргүүн Носиржон Аскарров тэргүүтэй баг оролцлоо.



Энэхүү хамтарсан семинарын туршид гурван улсын баг өөрийн улсад гэмт хэргийн статистикийг хэрхэн боловсруулж буй, гэмт хэргийн статистикийг ашиглан хэрхэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ашиглаж буй тухай, түүний үр дүн, өнөөгийн нөхцөл байдал,

цаашдын чиг хандлага, баримтлах бодлогын талаар тус тусын илтгэлүүдийг хэлэлцүүлж, харилцан туршлага солилцлоо. Өмнө нь Хууль зүйн үндэсний хүрээлэн, Япон Улсын Хууль зүйн яамны харьяа Сургалт, судалгааны хүрээлэн хамтран 2021 онд “Япон болон Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан

шийдвэрлэх тогтолцоо”, 2022 онд “Прокурорын чиг үүрэг, онцлог: Япон болон Монгол Улс”, “Өсвөр насны хүнд холбогдох эрүүгийн процессын ажиллагаа ба эрүүгийн хариуцлага: Япон ба Монгол Улсын харьцуулалт” сэдэвт семинаруудыг амжилттай зохион байгуулж байсан билээ.

## ЯПОН УЛСЫН НАГОЯ ИХ СУРГУУЛИЙН АЗИЙН ЭРХ ЗҮЙН СОЛИЛЦООНЫ ТӨВИЙН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах (Dr.jur), эрдэмтэн нарийн бичгийн дарга Г.Давааням (LL.D) нар Япон Улсын Нагоя Их Сургуулийн Азийн эрх зүйн солилцооны төв (CALE)-ийн захирал, профессор Масако Мураками, Нагоя Их Сургуулийн профессор Окочи Минори, профессор Фумито Сато нарыг 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр хүлээн авч уулзлаа. Хоёр байгууллага нь 2006 оноос хойш “Эрдмийн солилцооны хэлэлцээр”-ийн хүрээнд идэвхтэй хамтран

ажилласаар ирсэн бөгөөд энэ удаагийн уулзалтаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагаатай биечлэн танилцаж, цаашид хоёр талт хамтын ажиллагааг эрчимжүүлэх талаар санал солилцов. Түүнчлэн Монгол Улсад хийгдэж буй хувийн эрх зүйн шинэчлэл, тус хүрээлэнгээс хариуцан хөгжүүлж буй Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем ([www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)) болон “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт, мөн хууль тогтоох ажиллагаанд

иргэдийн оролцоог цахимаар хангаж буй “D.parliament” аппликейшний талаар туршлага судаллаа. Уг Нагоя Их Сургуулийн профессорууд нь Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль болон Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдөр хамтран зохион байгуулж буй “Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн суурь асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний IV хуралд оролцох юм.





## ЭРХ ЗҮЙН ХӨТЧИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран эрх зүйн хөтчийг чадавхжуулах сургалтыг 03 дугаар сарын 29-ний өдөр зохион байгууллаа. Сургалтад Налайх дүүргийн 15 эрх зүйн хөтөч хамрагдсан байна. Сургалтаар ХЗҮХ-ийн Сургалт хариуцсан мэргэжилтэн П.Аззаяа, Хууль зүйн мэдээлэл, сурталчилгааны мэргэжилтэн Э.Цэрэндүзээ нар эрх хөтчийн ажиллах журам, [www.e-khutuch.mn](http://www.e-khutuch.mn) цахим хуудас, түүний аппликейшн, [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) цахим хуудасны шинэчилсэн хувилбар болон эрх зүйн хөтчийн цахим сургалтын системийн танилцуулгыг хийлээ.





## “ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГА ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн сургалт зохион байгууллаа. Б.Болорсайхан заав. Тус үндэсний хүрээлэн, Сургалтад Цагдаагийн сургалт нь хуульчид болон Нийслэлийн засаг ерөнхий газрын 50 гаруй хууль сахиулах байгууллагын даргын Тамгын газартай алба хаагч хамрагдлаа. алба хаагчдын хүний эрхийн хамтран 2023 оны 3 дугаар Сургалтыг Хүний эрхийг талаарх ойлголт, мэдлэгийг сарын 15-ны өдөр “Хүний хангах Үндэсний хорооны нэмэгдүүлэх, хүний эрхэд эрхэд суурилсан хандлага нарийн бичгийн дарга суурилсан хандлага төлөвшүүлэх нь” сэдэвт бөгөөд Ажлын албаны дарга төлөвшүүлэх зорилготой юм.





## “ЖЕНДЕРИЙН ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТ БА ТЭГШ БАЙДАЛ” СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

**Ж**ендерийн үндэсний хорооноос санаачлан Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр “ХАРИЛЦАНХҮНДЭТГЭЭ” аяныг 2023 оны 03 дугаар сарын турш зохион байгуулж байна. Уг аяны хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн, сургалт, мэдээлэл, сурталчилгааны төвийн Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн ажилтан Д.Батням ШШГЕГ-ын харьяа 421 дүгээр нээлттэй хорих ангийн албан хаагч нарт “Жендерийн хэвшмэл ойлголт ба тэгш байдал” сэдэвт сургалт зохион байгуулсан. Нийт 15 алба хаагч хамрагдсан.



ИРГЭН ТАНД ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЛИЙГ ЭНГИЙН УТАСНЫ ТАРИФААР ХҮРГЭХ УТАС:



08:30-17:30

# 1800-1202

Эрх зүйн боловсролыг иргэн бүрд



## ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХАРИЛЦАА**  
(Хөдөлмөрийн тухай хууль/ Төвдугаар бүлэг)

Ажил олгогч ажилд орох гээг байгаа хүнтэй түүний гүйцэтгэх ажил үүрэг, цалин хөлсний хэмжээ, хөдөлмөр эрхлэлтийн бусад харилцан тохиролцоо бөгөөд ажилтан ажил үүрэг гүйцэтгэх хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүснэ.

**Мэдээлэл цуглуулах:**  
Хүнийг ажилд авах, ажилтантай харилцах зорилгоор хөдөлмөр эрхлэлтийн харилцааны явцад ажил олгогч нь ажилтнаас шаардлагатай мэдээллийг нь авч боловсруулж, хадгалж, ашиглаж болно. Ажилтны хувийн нууцад хамаарах, эсхүл улс төрийн нам, олон нийтийн байгууллага, үйлдвэрчний эвлэлийн гишүүнчлэлийн талаар мэдээлэл авах, боловсруулах, хадгалахыг хориглоно.

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХАРИЛЦАА**  
(Хөдөлмөрийн тухай хууль/ Төвдугаар бүлэг)

Хөдөлмөрийн гэрээнд дараах гол нөхцөлийг тусгана:

Ажлын байрны нэр, ажлын байрны тодорхойлолтод заасан гүйцэтгэх ажил үүрэг

Цалин хөлсний хэмжээ

Хөдөлмөрийн нөхцөл

Ажил үүрэг гүйцэтгэх байршил

www.legalinfo.mn  
QR кодыг гар утасныхаа камерар уншуулж, www.legalinfo.mn хуудсанд элчлээрэй.

1800-1202  
Хууль зүйн зөвлөгч, мэдээллийн эдийн улсын танинбар

Гар бүсийн хүчирхийллийн талаар мэдээлэл өгөх бол 7272-4001 дугаарт мессеж илгээх үү.

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХАРИЛЦАА**  
(Хөдөлмөрийн тухай хууль/ Төвдугаар бүлэг)

Талууд хөдөлмөрийн гэрээнд дараах нөхцөлийг нэмж тусгаж болно:

Хөдөлмөрийн гэрээг цуцлах, дуусгавар болгох үндэслэл

Ажил, амралтын цаг

Цалин хөлс олгох журам

Хөдөлмөрийн сахилга, томдол гаргах журам

Талууд харилцан тохиролцсон бусад

Ажлын байранд тавигдах үр чадвар, чадмжийн шаардлага

www.legalinfo.mn  
QR кодыг гар утасныхаа камерар уншуулж, www.legalinfo.mn хуудсанд элчлээрэй.

1800-1202  
Хууль зүйн зөвлөгч, мэдээллийн эдийн улсын танинбар

Гар бүсийн хүчирхийллийн талаар мэдээлэл өгөх бол 7272-4001 дугаарт мессеж илгээх үү.

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХАРИЛЦАА**  
(Хөдөлмөрийн тухай хууль/ Төвдугаар бүлэг)

Хөдөлмөрийн гэрээг доорх тохиолдолд хугацаатай байгуулана:

- Давалданаар ажиллуулах
- Туршилтын хугацаагаар ажиллуулах
- Улирлын шинэтэй ажил гүйцэтгүүлэх
- Ажлын байр нь хадгалагдаж байгаа ажилтны оронд ажиллуулах
- Түр ажлын байранд ажиллуулах
- Санхүүжилт, хийгдэх ажлын цар хүрээтэй холбоотой цаг хугацаагаар хязгаарлагдсан ажил үүрэг гүйцэтгүүлэх
- Улирлын шинэтэй ажил үүргийг байнга эрсэлдэг ажилтантай

www.legalinfo.mn  
QR кодыг гар утасныхаа камерар уншуулж, www.legalinfo.mn хуудсанд элчлээрэй.

1800-1202  
Хууль зүйн зөвлөгч, мэдээллийн эдийн улсын танинбар

Гар бүсийн хүчирхийллийн талаар мэдээлэл өгөх бол 7272-4001 дугаарт мессеж илгээх үү.

**ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ**

**УРЬДЧИЛСАН ТЭМДЭГЛЭЛИЙГ ДУУСГАВАР БОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ**

Урьдчилсан тэмдэглэл хийсэн нөхцөл хангагдсан, эсхүл эрх шилжүүлэн авагч тухайн үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэн авсан тохиолдолд **урьдчилсан тэмдэглэл дуусгавар болно.**

**Урьдчилсан тэмдэглэлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно**

- ✓ Эрх шилжүүлэн авагч үүргээ гүйцэтгээгүй нь баримтаар нотлогдсон
- ✓ Өмчлөгч, эзэмшигч, ашиглагч урьдчилсан тэмдэглэл хийлгэсний улмаас удаан хугацааны турш үл хөдлөх эд хөрөнгөө ашиглах боломжоо алдаж байгаа талаар Иргэний хуулийн 185.5-д заасны дагуу хүсэлт гаргасныг эрх шилжүүлэн авагч зөвшөөрсөн
- ✓ Гэрээслэгч гэрээслэлээ хүчингүй болгосон

1800-1202  
Хууль зүйн зөвлөгч, мэдээллийн эдийн улсын танинбар

www.legalinfo.mn  
QR кодыг гар утасныхаа камерар уншуулж, www.legalinfo.mn хуудсанд элчлээрэй.

Гар бүсийн хүчирхийллийн талаар мэдээлэл өгөх бол 7272-4001 дугаарт мессеж илгээх үү.

**ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ**

Урьдчилсан тэмдэглэл хийлгэхдээ бүрдүүлэх материал нь бүртгүүлэх шаардлагаас хамааран өөр өөр байна.

Барьж дуусаагүй барилгын эрх эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд бүрдүүлэх баримт бичиг:

- ✓ Захиалагчийн жагсаалт
- ✓ Захиалагчийн оруулсан хөрөнгийн хэмжээ
- ✓ Иргэний үнэмлэх
- ✓ Өргөдөл
- ✓ Үйлчилгээний хураамж

Урьдчилсан тэмдэглэлийг хаана хийлгэх вэ?

Урьдчилсан тэмдэглэл хийлгэх бүртгэлийг нийслэлд харьяа дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс болон нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд, орон нутагт Улсын бүртгэлийн хэлтэст хандан мэдүүлэг гаргаж, бүртгүүлнэ.

**ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХУГАЦАА**

Ажлын 3 өдрийн дотор багтаан эрхийн улсын бүртгэлд бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1 дэх хэсэг, 31 дүгээр зүйл.